



**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**



Агуулга

1	АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ	3
2	АУДИТЫН ТАЙЛАН	5
2.1.	Оршил.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.8.1	Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:	9
	Эх сурвалж: 2018 оны санхүүгийн аудитын тайлан.....	10
2.8.2	Төсвийн шууд захирагч, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитын дүнгийн талаар	10
2.8.3	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар	11
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	11
2.11.	Шилэн дансны мэдээлэл	12
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	12
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	13
3	МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ	14
3.1	Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа.....	14
3.2	Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа.....	15
3.3	Орлогын данстай холбоотой асуудал.....	16
3.4	Балансын данстай холбоотой асуудал.....	17
3.5	Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа.....	17
3.6	Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа.....	18
3.7	Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа.....	18
4	АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	20
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	20
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	22
4.3	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	24
4.4	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	26
4.5	Аудит хийгдсэн жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан	27
5	ХАВСРАЛТ.....	29
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	29



Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨААН	Төрийн өмчит аж ахуйн нэгж
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ЗГ	Засгийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
НДС	Нийгмийн даатгалын сан
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
НДҮЗ	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
Д.САРАНГЭРЭЛ ТАНАА

2019.04.25 № 862
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2018 оны төсвийн гүйцэтгэл, нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Аудитын гол асуудал

Монгол банкны ерөнхийлөгчийн 2019 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн А-96 дугаар тушаалаар Капитал банкны татан буулгаснаар Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайланд тусгагдсан тус банканд байрших мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 131,824.1 сая төгрөг (2019 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл 134,862.7 сая төгрөг) нь “оршин байх”, “эрх ба үүрэг”¹ батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг хариуцлага

Сангийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.БҮРЭНБАТ



2 Аудитын тайлан

2.1. Оршил

Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын систем, мөрдлөг болгож буй дүрэм журмыг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Эрүүл мэндийн даатгалын сангийн удирдлага санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 4 дүгээр сарын 05-ны өдрөөс 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Л.Хонгорзул, аудитор Л.Мөнхцацрал нар хэрэгжүүлэв.

Эрүүл мэндийн даатгалын сан 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2019 оны 4 дүгээр сарын 5 -ны өдрийн А-1/380 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.



2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБООУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан заавар аргачлалын дагуу горим сорилыг гүйцэтгэн, үе шатны чанарын хяналтыг хийлгэн, холбогдох нотлох зүйлсийг баталгаажуулан, баримтжуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНБООУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын талаарх ерөнхий мэдээллийг А101 маягтаар баталгаажуулсан.

Эрхэм зорилго:

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь Монгол хүн бүрийг эрүүл мэндийн даатгалд хамруулж, даатгалын тогтвортой санг бүрдүүлэн, даатгуулагчийн хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг худалдан авдаг үйлчлүүлэгч төвтэй, нийгмийн хариуцлага бүхий менежментийг хэрэгжүүлэхэд оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг бүрдүүлж, даатгуулагчийн өмнөөс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа эрхэлж байна.

Үүнд: Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, эрүүл мэндийн даатгалын сан бүрдүүлэх, орлого, зарлагын тэнцвэрийг ханган ажиллах, даатгуулагчийг төлөөлж магадлан итгэмжлэгдсэн өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагаас сонгон шалгаруулж, гэрээ байгуулах, гэрээний биелэлтэд хяналт тавих, даатгуулагчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Тайлант онд давхардсан тоогоор 3,067.8 мянган даатгуулагчийг эрүүл мэндийн даатгалд хамруулж, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон Үндэсний зөвлөлийн шийдвэрийн дагуу 1632 эрүүл мэндийн байгууллагатай даатгалын гэрээ байгуулж, давхардсан тоогоор 7,342.0 мянган даатгуулагчид тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн удирдлага төсөв захирагчийн хувьд дараах хууль болон УСНБООУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан



бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль

Тайлант хугацаанд Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бие даасан бүтцийг бий болгох, эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор дээрх бодлого, хуулийг дагалдуулж 20 гаруй тогтоол, журмыг баталж, эрх зүйн орчинд томоохон шинэчлэлт, өөрчлөлт хийсэн байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам;
- Эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг зарцуулах, банканд хадгалуулах, Засгийн газрын бонд, Монгол банкны үнэт цаас худалдан авах журам;
- “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай;
- Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим тусламж үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах журам;
- Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг шинэчлэн батлах болон бусад журам.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Эрүүл мэндийн даатгалын сан салбарын онцлог, бүртгэлийн суурь, зарчимд нийцсэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөөгүй байна.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд аудитад мэдээллийн технологийн мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.



Санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Харин үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Их” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөгүй” гэж үзлээ.

Дотоод аудитын алба байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн эсэх нь тодорхойгүй, аудитын явцад хэрэгжүүлсэн ажлын тайлан, мэдээллийг гаргаж өгөөгүй болно.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, түүнтэй холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнг сонгов.

Энэ нь оны эхэнд өндөр дүнтэй мөнгөн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж бүртгэсэнтэй холбоотой орлого, зардалд их хэмжээтэй өөрчлөлт гарсан тул хэлбэлзэл багатай нийт хөрөнгийг материаллаг байдлын сууриар сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшинг Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны Санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө 581,934.6 сая төгрөгийн хоёр хувь буюу 11,638.7 сая төгрөгөөр тогтоосон.

Материаллаг байдлын түвшинг суурь үзүүлэлтээс 2 хувиар тооцсон нь Эрүүл мэндийн даатгалын сан нь 2018 онд эхлэлтийн тайлан гаргаж байгаатай холбоотой юм.

Гүйцэтгэлээр төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын суурь үзүүлэлт болон хувийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн ба Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгийн дүн 596,906.1 сая төгрөгийн хоёр хувиар 11,938.1 сая төгрөгөөр тооцсон болно.



2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж гаргалаа.

Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүгийн үйл ажиллагаа ЭМДҮЗ, 21-н аймаг, 2 дүүргийн тасаг, төв сан, нийт 25 нэгжийг хамарч байгаа боловч орон нутаг, дүүрэгт байрлах 23 тасаг нь бие даасан санхүүгийн тайлан толилуулаагүй бөгөөд төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн мэдээ гаргаж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Төсвийн шууд захирагчийн 2, Засгийн газрын тусгай сангийн 1, нийт 3 санхүүгийн тайлан нэгтгэгдэж, аудитад хамрагдсан байна.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №1 Аудит хийсэн хэлбэр

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Үүнээс: Гэрээгээр хийлгэсэн	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	2				
2	Тусгай сан	1				
3	Төсвийн ерөнхий захирагч	1				
	Дүн	4				

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий аудиторовын А/156 дүгээр тушаал

Аудитаар 2 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 2 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 436,161.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 67.6 хувь буюу 294,671.0 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 0.1 хувь буюу 641.3 сая төгрөгийн зөрчилд акт тогтоож, 0.4 хувь буюу 1,543.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 31.9 хувь буюу 139,305.5 сая төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлж ажиллаа.

Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.



Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

Хүснэгт №2 Алдаа, зөрчилтэй асуудлын ангилал

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс:					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТШЗ	12	1,008.9	3	641.3	5	349.0	4	18.6
2	Засгийн газрын тусгай сан /ТТЗ/	8	8,657.7			2	1,194.9	6	7,462.8
3	ТЕЗ	7	131,824.1					7	131,824.1
	Дүн	27	141,490.7	3	641.3	7	1,543.9	17	139,305.5

Эх сурвалж: 2018 оны санхүүгийн аудитын тайлан

2.8.2 Төсвийн шууд захирагч, Төсвийн төвлөрүүлэн захирагчын аудитын дүнгийн талаар

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитаар:

- ЭМДҮЗ-ийн гишүүдийн урамшууллын дээд хэмжээг Улсын Их Хурлын Байнгын хороогоор батлуулаагүй, сар бүр тооцон олгосон;
- Бараа материалын дэлгэрэнгүй тайланг бэлтгээгүй, анхан шатны баримт бүрдүүлээгүй;
- Үндсэн хөрөнгө, бараа материалын жилийн эцсийн тооллого хийж, тулган баталгаажуулаагүй зэрэг 25.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитаар:

- Бараа материалын тайлан бэлтгээгүй, баримт бүрдэлгүй 119.2 сая төгрөгийн гүйлгээг бүртгэсэн, жилийн эцсийн тооллого хийж үлдэгдлийг тулган баталгаажуулаагүй;
- ЭМДЕГ-ийн урсгал зардлын дансны жилийн эцсийн үлдэгдэл 637.5 сая төгрөгийг төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлээгүй;
- Тайлант онд 226.5 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, нээлттэй тендер зарлалгүй урсгал зардлаас бэлтгэсэн зэрэг нийт 983.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар:

- Эрүүл хүүхэд аяны хүрээнд урьдчилж гарсан зардал 444.4 сая төгрөгийг шийдвэрлэх тухай өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй;
- Сангаас шилжүүлэгдсэн зардлын гүйлгээний төлбөрийн хүсэлтийг, нэхэмжлэх болон бусад анхан шатны баримтаас тусад нь архивласан, 2018 оны 3 дугаар



улирлын 14,440 гүйлгээний төлбөрийн хүсэлтийн дүн, анхан шатны баримтын дүнгээс зөрүүтэй, түүвэрт хамрагдсан байгууллагад олгосон санхүүжилтийн дүн, анхан шатны баримтын дүнгээс 750.5 сая төгрөгөөр зөрүүтэй;

- Төрөөс хариуцах иргэдийн ЭМДШ-ийн 6,715.8 сая төгрөгийн авлагыг хариуцагч ХНХЯ-тай тооцоо нийлэхдээ тайлант жилийн гүйцэтгэлээр дүгнэж, авлага, өр төлбөргүй гэж баталгаажуулсан;
- 2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй, НБББББ боловсруулж мөрдөөгүй, аудитын шаардсан зарим баримт, мэдээллийг заасан хугацаанд ирүүлээгүй зэрэг зөрчил илэрч, 1,194.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 7,462.8 сая төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлсэн байна.

2.8.3 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 7 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцохоор шийдвэрлэлээ.

Аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд тусгав.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

2.9.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн 22 аймаг болон Багануур, Налайх дүүрэгт байрлах салбарууд санхүүгийн тайлан толилуулдаггүй боловч төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэж, тусламж үйлчилгээний зардлын гүйлгээнд хяналт тавьж, анхан шатны баримтыг бүрдүүлж байна. Орон нутгийн салбарууд 2018 онд 110,191.7 сая төгрөгийн зардлын нэхэмжлэх, гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулжээ. Сангийн төсвийн тусламж үйлчилгээний зардлын 35.2 хувийг зарцуулж буй эдгээр салбаруудад УАГ-ын аудитын баг хүрч ажиллах боломжгүй тул орон нутаг дахь Төрийн аудитын байгууллагын зүгээс төсвийн гүйцэтгэл, зардлын гүйлгээнд аудитын үе шатны ажлыг гүйцэтгэх нь зүйтэй байна.

2.9.2 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2018 оны санхүүгийн тайланг толилуулсан төсвийн эдийн засгийн ангилал нь салбарын онцлогийг бүрэн илэрхийлэх боломжгүй тул сангийн эх үүсвэрийг Нийгмийн даатгалын сангаас санхүүжих, зардлыг татаас, урсгал шилжүүлгийн ангилалд бүртгэсэн байна. НБББББ-г боловсруулахдаа салбарт нийцсэн эдийн засгийн ангиллыг тусгах талаар Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтарч ажиллах нь ач холбогдолтой болохыг тэмдэглэж, энэ талаар дараагийн аудитаар горим сорил хэрэгжүүлэх.

2.9.3. ЭМДЕГ-ийн Хан-Уул дүүрэгт байрлах барилгыг Засгийн газрын 344-р тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 46 тогтоолыг тус тус үндэслэн 2018 оны санхүүгийн тайланд 1,198.2 сая төгрөг (анхны өртгөөр)-р ЭМНДЕГ



(хуучин нэрээр)-ийн балансаас балансад шилжүүлэн бүртгэсэн байна. Гэвч тус барилгын үл хөдлөх хөрөнгө эзэмших эрх шилжиж ирээгүй, барилгын үнэ тодорхойгүй байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 46-р тогтоол болон хавсралтад барилгын үнийг 2,491.8 сая төгрөгийн зөрүүтэй баталсны, хавсралтын дүнгээр хүлээн авч бүртгэсэн байна.

2.10 Төсвийн төлөвлөлт, зарцуулалт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангийн хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулан 341,330.5 сая төгрөгийн төсөв зарцуулах, эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Тайлант онд орлогын төлөвлөгөө 376,011.9 сая төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 411,076.1 сая төгрөгийг төвлөрүүлж, 109.3 хувьтай байна.

Зардлын төсөв 341,330.5 сая төгрөг, нийт гүйцэтгэл 311,736.4 сая төгрөг буюу 91.3 хувьтай байгаа нь урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгооны зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал болон бусад зардал хэмнэгдсэнтэй холбоотой байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Эрүүл мэндийн даатгалын сан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансанд байгууллагын санхүүгийн тайлан, орон тоо, төсвийн төсөл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээний мэдээлэл зэрэг нийт 16 төрлийн 149 мэдээлэл оруулсны 81.9 хувь нь хугацаа хоцроосон байна. 2018 оны 4 дүгээр улирлын тайланг 2019 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр илгээсэн байна. Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж, 3 албан шаардлага өгснөөс 2 албан шаардлагыг биелүүлж, дунджаар 80 хувийн биелэлттэй байна.

Эрүүл хүүхэд аян хөтөлбөрийн хүрээнд ЭМДС-гаас 2013 онд дүүрэг, орон нутгийн эмнэлгүүдэд “0-18 насны хүүхдийн эрүүл мэндийн үзлэг оношилгоо”-нд зориулж олгосон 445.9 сая төгрөгийн урьдчилж гарсан зардлыг шийдвэрлэх албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны



санхүүгийн тайланд (Нийгмийн даатгалын сангийн балансас) 444.0 сая төгрөгөөр шилжүүлж бүртгэсэн байна.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримтаар баталгаажуулж, гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2018 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Эрүүл мэндийн даатгалын сангийн Капитал банканд байршиж буй 131,824.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгөд эрсдэл үүссэн байна. Үүнд:

1. Тайлант оны эхэнд Нийгмийн даатгалын сангаас Капитал банканд байрших 122,537.7 сая төгрөгийн харилцах дансны үлдэгдэл, 10,000.0 сая төгрөгийн мөнгөн хадгаламж, нийт 132,537.7 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг балансаас балансад хүлээн авч бүртгэсэн байна.

Монгол банкны ерөнхийлөгчийн 2019 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн А-96 дугаар тушаалаар Капитал банкиг албадан татан буулгаснаар Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлангийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлд тусгагдсан Капитал банкны 131,824.1 сая төгрөгийн (2019 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл 134,862.7 сая төгрөг) мөнгөн хөрөнгийн үлдэгдэл “оршин байх”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн удирдлага нь Капитал банкнаас Төрийн сангийн холбогдох харилцах дансанд төвлөрүүлэхээр хийсэн шилжүүлэг саатаж, үйл ажиллагаа доголдож байгаа талаар УИХ-ын НББСШУ-ны байнгын хороо, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, Монгол банк зэрэг холбогдох байгууллагад удаа дараа мэдэгдэж, хүсэлт уламжлах, банкаар хүлээн авах орлогыг хязгаарлах, зарлагын



гүйлгээ хийх, харилцахын мөнгийг хадгаламжид шилжүүлэх зэргээр хууль, эрх зүйн хүрээнд авах ёстой арга хэмжээг авч ажилласан байна.

2. Эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг зарцуулах, банканд хадгалах, Засгийн газрын бонд, Монгол банкны үнэт цаас худалдан авах журмын 4 дүгээр зүйл "Мөнгөн хадгаламж байршуулах банканд тавигдах шаардлага"-ийн 4.1.3 - т "хадгаламжийн үлдэгдлийн хэмжээ нь тухайн банкны нийт активын 20 хувиас хэтрэхгүй байх" гэж заасан нь бусад сангуудын тогтоосон дээд хэмжээнээс 5-15 хувиар илүү байна.

3.1.2 Эрсдэл:

Арилжааны банкны үйл ажиллагааны тогтворгүй байдлаас байгууллага ихээхэн хэмжээний алдагдал хүлээх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

1. Капитал банканд байрших Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгөд үүссэн эрсдэлийг бууруулах, болзошгүй алдагдлаас урьдчилан сэргийлэх;

2. Цаашид арилжааны банканд хадгаламж байршуулахдаа Монгол банкнаас тогтоосон заавал байлгах нөөц (ЗБН)-ийн хувь хэмжээ, банкны ашиг алдагдал, чанаргүй зээлийн хэмжээг харгалзаж байх;

3. Журмын "...хадгаламжийн үлдэгдлийн хэмжээ нь тухайн банкны нийт активын 20 хувиас хэтрэхгүй байх" гэсэн заалт нь жижиг банкуудад хадгалуулсан хадгаламжид эрсдэл үүсгэх гол хүчин зүйл болох тул тогтоосон хувь хэмжээг бууруулах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг В501 маягтаар хураангуйлан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын холбогдох албан тушаалтанд танилцуулахад, хүлээн зөвшөөрсөн болно.

3.2 Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн үйл ажиллагаа

3.2.1 Илрүүлэлт:

1. Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн үйл ажиллагааг зохицуулах журмыг 2018 оны 3 дугаар сард баталсан, сангийн төсвийг 2018 онд төлөвлөөгүйн улмаас эрсдэлийн санг тайлант онд байгуулаагүй байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн орлогын 10 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр байгуулна" гэж заасанд нийцэхгүй байна.

2. ЭМДҮЗ-ийн 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 5 дугаар тогтоолоор баталсан "Эрсдэлийн сангийн чөлөөт үлдэгдлийг зарцуулах, банканд хадгалуулах, Засгийн газрын бонд, Монгол банкны үнэт цаас худалдан авах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1, 4.2.2 дугаар заалтууд нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сан, түүнийг банканд хадгалуулснаас олсон орлого, эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг гэнэтийн давагдашгүй хүчин зүйл болон эдийн засаг, санхүүгийн хүндрэлийн нөлөөгөөр үүсэх эрүүл мэндийн даатгалын сангийн алдагдлыг нөхөж, уг сангийн



тогтвортой байдлыг хангах зорилгоор энэ хуулийн 14.8.2, 14.8.3-т заасан журмын дагуу зарцуулна" гэсэн заалтад нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

1. Журамд эрсдэлийн сангийн мөнгөн хөрөнгийг удирдах зарчим, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, хяналт, хариуцлага, тайлагналын талаар нэмэлт заалтуудыг тусгах;

2. Санг байгуулах зайлшгүй нөхцөл үүсч байгааг харгалзан хуулийг хэрэгжүүлэх шат дараалсан арга хэмжээ авах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг В501 маягтаар хураангуйлан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын холбогдох албан тушаалтанд танилцуулахад, хүлээн зөвшөөрсөн болно.

3.3 Орлогын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Эрүүл мэндийн даатгалын сан нь 2018 оноос бие даасан бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасны дагуу даатгуулагч болон ажил олгогчийн төлөх ЭМДШ, алдангийн орлогыг Нийгмийн даатгалын сангаар дамжуулан хүлээн авч байна. Тайлант онд дээрх төрлийн орлогыг НДС-гаас ирүүлсэн мэдээнд үндэслэн мөнгөн сууриар бүртгэснээс гадна орлогын хэрэгжилтэд хяналт тавих эрх зүйн нөхцөлөөр хангагдаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйл "Санхүүгийн бүртгэл, стандарт"-ийн 26.1-т "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузал суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэсэн заалтад нийцэхгүй байна

3.3.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлагналын стандарт мөрдөгдөхгүй байх, тайлант оны үр дүн буруу илэрхийлэгдэх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Цаашид шимтгэлийн орлогыг цуглуулах, төвлөрүүлэх үйл ажиллагааг бие дааж гүйцэтгэх нөөц ба эрх зүйн орчныг бий болгох шат дараалсан бодлогын арга хэмжээ авч ажиллах

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг В501 маягтаар хураангуйлан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын холбогдох албан тушаалтанд танилцуулахад, хүлээн зөвшөөрсөн болно.



3.4 Орлогын данстай холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

